

# Химийн урвалаас үүдэлтэй осол хаана ч гарч болзошгүй! 2020-12 cap



Зургийн тайлбар: “Buffalo Wild Wings рестораны ажилтан цэвэрлэгээ хийж байгаад амми алдав” (Хими, Инженерийн мэдээ сэтгүүл, 2019 оны 11 сарын 18, 6-р нүүр.)



## 2016 оны 6 сарын Beacon

Таны ажлын байранд ямар нэгэн химийн бодисын урвал үүсэхгүй учраас та өөрийгөө химийн урвалаас болж осол гарах вий гэдэгт санаа зовох шаардлагагүй гэж бодож байна уу? Энэ бодолдоо бүү хууртаарай – Химийн бодисын урвалаас үүдэлтэй осол хаана ч гарч болзошгүй байдаг. Доорх 2 ослын жишээг харцгаая.

2019 оны 11 сарын 7-нд АНУ-н Масачусетс мужийн Бюрлингтон хотын рестораны ажилтан “Scale Kleen” нэртэй цэвэрлэгээний бодисыг санамсаргүй шалан дээр асгачихжээ. Дараа нь өөр нэг ажилтан бас нэг төрлийн цэвэрлэгээний бодис болох “Super 8”-г ашиглан шалыг цэвэрлэж эхэлсэн байна. Химийн бодисууд урвалд орж хлорийн хорт хий ялгаруулсан. Ресторанд байсан хүмүүсийг өөр газарт шилжүүлсэн. Харамсалтай нь рестораны менежер ууршсан хийнд өртөж улмаар эмнэлэгт нас баржээ. Химийн бодисын аюулгүйн зааварчилгаанд дурдсанаар “Super 8” цэвэрлэгээний бодист гэрийн нөхцөлд ашигладаг цайруулагч бодисоос их хэмжээтэй буюу 10%-н содын гипохлорид (цайруулагч бодис) агуулсан байв. “Scale Kleen” цэвэрлэгээний бодис нь азотын болон фосфорын хүчил хоёуланг нь агуулсан, нийт уусмалын чанар нь бараг 40%-д хүрсэн байв.

Энэ ослоос хойш хэд хоногийн дараа (11 сарын 19-нд) Масачусетсийн Вөүбюрн хотын ойролцоох ресторанд хоёр өөр төрлийн цэвэрлэгээний шингэн холилдож хортой хий агаарт тархсан осол гарсан. Ресторанд байсан хүмүүсийг нүүлгэн шилжүүлж, 3 хүнийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар эмнэлэгт хүргэсэн.

## Та үүнийг мэдэх үү?

- Цэвэрлэгээ болон засвар үйлчилгээнд ашигладаг олонх химийн бодисууд бусад төрлийн бодистой урвалд ордог. Үүнд цэвэрлэгээний бодисууд багтдаг ба химийн урвалд хялбар ордог байдал нь тухайн цэвэрлэгээний бодисыг сайн чанарынх гэдгийг илтгэх нэг үзүүлэлт байж болно.
- Цайруулагч бодис нь хүчил гэх мэт бусад төрлийн бодистой химийн урвалд ордог нь тодорхой аюулыг бий болгож байдаг. 2016 оны 6 сарын энэхүү сануулгаар содын гипохлорид агуулсан цайруулагч бодис аммиактай холилдож хортой хлорамин ялгаруулдаг талаар дурдаж байсан.
- Аливаа цэвэрлэгээг хийсний дараа тоног төхөөрөмжөөс тухайн цэвэрлэгээний бодисыг бүрэн арилгаагүй тохиолдолд үйл ажиллагаанд ашигладаг бусад химийн бодистой урвалд орж болзошгүй байдаг.

## Та юу хийж чадах вэ?

- Ус цэвэршүүлэх, шингэнийг хөргөх эсвэл халаах зэрэг нийтийн аж ахуйн хэрэгсэлд болон ажлын байран дээр цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, тосолгоо хийх үед химийн бодис ашиглах бол тухайн химийн бодисын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудсыг уншиж, танилцах.
- Химийн бодисын аюулгүй ажиллагааны хуудаст тухайн материалын урвалд орох бүх аюулыг багтаасан байдаггүй гэдгийг сана. Өөрийн ажилладаг газарт ашигладаг тодорхой химийн бодисуудын урвалд орох аюулын талаар химич эсвэл бусад техникийн мэргэжилтнүүдээс асуух хэрэгтэй.
- Өөрийн ажилладаг хэсэгт шинэ төрлийн химийн бодис ашиглах бүртгээ гарч болзошгүй бүхий л химийн урвалын аюулын талаар бодож үзэх.
- Цэвэрлэгээг нарийвчилсан шат дарааллын дагуу хийх, ялангуяа цэвэрлэгээ хийсний дараа тоног төхөөрөмжөөс цэвэрлэгээний материалыг бүрэн арилгасан эсэхийг сайтар шалгах.
- Гарч болох химийн урвалын аюул болон түүнээс хамгаалах арга хэмжээний талаар ойлголгүйгээр химийн бодисыг хэзээ ч бүү холь.
- 2016 оны 6 сард цайруулагч бодисын химийн урвалын аюулын талаар танилцуулсан сэрэмжлүүлгийг доорх линкээр орж уншина уу. (<https://www.aiche.org/ccps/resources/process-safety-beacon/archives>)
- Энэ сэрэмжлүүлгийн талаар гэр бүл, найз нөхдөдөө дамжуулаарай – Энэ төрлийн осол хаана ч, танай гэрт ч гарч болзошгүй гэдгийг санаарай!

**Аюулгүй гэдгийг нь мэдээгүй бол химийн бодисуудыг хооронд нь хэзээ ч бүү холь!**